

**Европын Холбооны байгаль орчинтой холбогдолтой  
хууль тогтоомж, дүрэм журам (Агаарын чанар ба хяналт –  
бодит туршлага ба Монголын нөхцөлд авч хэрэгжүүлэх боломжтой зүйлс)**

„Монгол орон дахь агаарын бохирдол” олон улсын семинарт *Доктор Арнольдс  
Юбелисийн тавьсан илтгэл*

2007 оны 8 дугаар сарын 27-29, Улаанбаатар хот  
Монголын Хөгжлийн Хүрээлэн, Монгол улсын Шинжлэх Ухааны Академи

Европын Холбоо нь 27 орноос бүрддэг.  
Хууль тогтоох ба эрх барих дээд байгууллагууд нь:  
Европын Парламент  
Европын Консул  
Европын Комисс зэрэг болно.  
Үүнээс Европын Комиссын Байгаль орчны Ерөнхий удирдлагын газар (ЕУГ) нь  
байгаль орчны асуудлыг хамаардаг.

**Байгаль орчны ЕУГ-ын эрхэм зорилго:**

**“Өнөөгийн болон ирээдүй үеийнхнийхээ төлөө хүрээлэн буй орчноо хайллан хамгаалж, хэвээр хадгалан улам сайжруулах, тогтвортой хөгжлийг дэмжих явдал” гэж тодорхойлогдсон.**

Европын Комиссын Байгаль орчны Ерөнхий удирдлагын газар (ЕУГ)-ын үндсэн чиг үүрэг нь байгаль орчны талаарх шинэ хууль дүрмийг санаачлан боловсруулах, нэгэнт батлагдсан хууль тогтоомжуудын хэрэгжилтийг ЕХ-ны гишүүн орнуудад хангах явдал юм.

Байгаль орчны ЕУГ нь Брюссель хотноо байрладаг ба 650 орчим ажиллагсадтай.

- **Байгаль орчны ЕУГ-ын цахим хуудас:**  
<http://ec.europa.eu/dgs/environment/directory.htm>

**Байгаль орчны ЕУГ-ын бүрэлдэхүүн:**

- **Байгаль орчны ЕУГ-ын Комиссар Stavros Dimas**
- **Захиргааны хэлтэс**
- **А хэлтэс: Харилцаа холбоо, Хууль эрхзүйн асуудлууд, Хүн амын хамгаалал**
- **В хэлтэс: Хүрээлэн буй орчны хамгаалал**
- **С хэлтэс: Уур амьсгалын өөрчлөлт ба Агаар**
- **Д хэлтэс: Ус, Химийн бодис ба Нэгдлүүд**

- E хэлтэс: Олон улсын харилцаа, LIFE
- F хэлтэс: Нөөц баялгууд / эх үүсвэрүүд
- G хэлтэс: Тогтвортой хөгжил ба интеграцчлал
- Захиргааны хэлтэс нь Газрын ерөнхий захиралд шууд харьяалагдана.

**ENV.1 Стратеги төлөвлөлт ба үнэлгээ**

Nicholas BANFIELD, утас 322 296.87.61

**ENV.2 Хууль боловсруулалт ба байгууллагын дотоод ажил**

Paulus BROUWER, утас 322 295.41.25

**ENV.3 Дотоод аудит**

Jan Julius GROENENDAAL, утас 322 299.22.71

- C хэлтэс: Уур амьсгалын өөрчлөлт ба Агаар

**Захирал Jos DELBEKE, утас 322 296.88.04**

**C1. Уур амьсгалын стратеги, олон улсын гэрээ хэлэлцээрүүд, EX-ны үйл ажиллагааны хяналт.**

Хэсгийн дэд дарга Artur RUNGE-METZGER, утас 322 295.68.98

Laurence GRAFF, утас 322 296.05.18

**C2. Зах зээл дээр суурилсан арга хэрэгслүүд, түүний дотор хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах арга замууд**

Хэсгийн дэд дарга Yvon SLINGENBERG, утас 322 299.20.36

Damien MEADOWS, утас 322 299.63.19

**C3. Цэвэр агаар ба Зам тээвэр**

Marianne KLINGBEIL, утас 322 296.04.93

**C4. Үйлдвэрлэлийн хаягдлууд, Озона давхаргын хамгаалал**

Хэсгийн дэд дарга Marianne WENNING, утас 322 295.59.43

Thomas VERHEYE, утас 322 295.96.39

**C5. Эрчим хүч ба Байгаль орчин**

Хэсгийн дэд дарга Piotr TULEJ, утас 322 299.97.32

Matti VAINIO, утас 322 299.61.38

- E хэлтэс: Олон улсын харилцаа, LIFE

**Захирал Soledad BLANCO, утас 322 299.51.82**

**E1. Олон улсын харилцаа, Засаглал ба Хөгжил**

Хэсгийн дэд дарга Astrid SCHOMAKER, утас 322 296.96.41

John DUNN, утас 322 296.13.17

**E2. Байгаль орчны холбогдолтой гэрээ хэлэлцээрүүд, үйл ажиллагаа**

Хэсгийн дэд дарга Hugo-Maria SCHALLY, утас 322 295.85.69

Julius LANGENDORFF, утас 322 299.88.29

- **Цэвэр агаар:** 1970-аад оны сүүлч үеэс эхлэн агаарын бохирдол нь Европын улс төрийн анхаарал татсан асуудлын нэг байсаар ирсэн. Агаарын чанарын талаарх Европын Холбооны бодлого нь агаарын чанарыг сайжруулах тохиromжтой арга хэрэгслүүдийг боловсруулан хэрэгжүүлэхэд чиглэгдэж байна. Энэхүү зорилгын хүрээнд хөдөлгөөнт эх

үүсвэрүүдээс ялгараах хорт хаягдлыг бууруулах, түлшний чанарыг сайжруулах, хүрээлэн буй орчны хамгааллыг зам тээвэр ба эрчим хүчиний салбарын хөгжлийн салшгүй нэг хэсэг байлгах зэрэг зорилтуудыг тавин ажиллаж байна. Байгаль орчинд хорт нөлөө үзүүлэгч бодисууд ба тэдгээрийн хүний эрүүл мэндэд нөлөөлөх байдлын талаарх ерөнхий мэдээллийг ДЭМБ-ын [Air Quality Guidelines](#) гэсэн баримт бичгээс, агаарын бохирдолд нөлөөлөгч бусад хүчин зүйлсийн талаарх мэдээлэл, тоо баримтыг [EEA](#)-аас тус тус олж үзэх боломжтой.

- [Хүрээлэн буй орчны 6 дахь мөрийн хөтөлбөрийн \(EAP\) "Хүрээлэн буй орчин 2010: Бидний ирээдүй, Бидний сонголт"](#) гэсэн хэсэгт:  
„Хүрээлэн буй орчин ба Хүн төрөлхтөний эрүүл мэнд нь нэн ойрын хугацаанд онцгой анхаарч арга хэмжээ авах шаардлагатай байгаа 4 зорилтын нэг болж байна” гэж цохон тэмдэглэсэн.  
**Агаарын бохирдол** нь Хүрээлэн буй орчин ба Эрүүл мэндийн асуудалтай нягт холбогддог. Холбоноос агаарын чанарын талаар явуулж буй үйл ажиллагаа зохих үр дүнд хүрч байгаа хэдий ч энэ чиглэлээр цаашид хийгдэх ажил маш их байна. Хүрээлэн буй орчны 6 дахь мөрийн хөтөлбөрт тусгагдсан зорилтын нэг нь агаарын чанарын түвшинг хүний эрүүл мэнд ба байгаль орчинд учирч буй хүлцэшгүй нөлөөлөл, эрсдэлийг цаашид нэмэгдүүлэхгүй байх хэмжээнд хүргэх явдал юм. Агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр Холбоноос олон талт арга хэмжээ авч хэрэгжүүлж байгаагийн заримаас дурьдвал: гишүүн орнуудын түвшинд мөрдөгдөх хууль дүрэм боловсруулах, мөн олон улс дамнасан бохирдлыг арилгах зорилгоор илүү өргөн хүрээнд үйл ажиллагаа явуулах, агаарын бохирдлын асуудалтай холбогддог салбурууд, үндэсний болон бүс нутгийн засаг захиргаа, ТББ-уудтай хамтран ажиллах, судалгаа шинжилгээ хийх зэрэг болно.
- [Агаарын бохирдолтой тэмцэх стратегийн тусгай хөтөлбөр CAFE, түүний хэрэгжилт](#)
- **Орчны агаарын чанар**
- **Агаарын чанарын талаарх шинэ санал санаачлага**
- **Агаарын чанарын чиглэлээрх хууль тогтоомж, тэдгээрийн хэрэгжилт**
- **Холбогдох бусад хуудсууд**
  - [Зам тээврийн хурц асуудлууд – хүн амд учирч буй эрсдэлүүд](#)
  - [Агаарыг бохирдуулагч бодисуудын ялгарал](#)
  - [Европын хорт бодисын ялгарлын бүртгэл \(EPER\)](#)
  - [Зам тээвэр ба Байгаль орчин](#)
- **Агаарын чанарын чиглэлээр одоо мөрдөгдөж буй хууль тогтоомжууд ([http://ec.europa.eu/environment/air/existing\\_leg.htm](http://ec.europa.eu/environment/air/existing_leg.htm))**

Орчны агаарын чанарын талаарх хэд хэдэн хууль тогтоомж Консул ба Европын Парламентаар батлагдан Холбооны түвшинд мөрдөгдөж байна. Үүнд:

- 1. Консулын тогтоол 96/62/ЕС.** Энэхүү тогтооюуд орчны агаарын чанарын үнэлгээ ба менежментийг тодорхойлж өгсөн ба [Агаарын Чанарын Үндсэн Тогтоол](#) гэж нэрлэгддэг. Энэхүү баримт бичигт Гишүүн орнуудад агаарын чанарыг хэрхэн хянаж, удирдах тухай үндсэн зарчмуудыг тодорхойлсон. Агаарын чанарын стандарт, зорилтуудыг боловсруулан хуульчлах үйл ажиллагаанд ашиглагдах агаар бохирдуулагч бодисуудын жагсаалтыг оруулсан.
- 2. Консулын тогтоол 1999/30/ЕС.** Орчны агаар дахь хүхрийн давхар исэл, азотын давхар исэл, азотын оксидууд, тоосонцор /particulate matter/ ба тугалгын зөвшөөрөгдөх дээд хэмжээг тодорхойлж өгсөн. "[Нэгдүгээр Дэд Тогтоол](#)" гэж нэрлэгддэг.
- 3. Европын Парламент (ЕП) ба Консулын тогтоол 2000/69/ЕС.** Орчны агаар дахь бензол ба нүүрстөрөгчийн дан ислийн зөвшөөрөгдөх дээд хэмжээг тодорхойлж өгсөн. "[Хоёрдугаар Дэд Тогтоол](#)" гэж нэршсэн.
- 4. ЕП ба Консулын тогтоол 2002/3/ЕС.** Орчны агаар дахь озоны тухай энэхүү баримт бичиг нь "[Гурвуудгаар Дэд Тогтоол](#)" гэж нэршсэн. Агаар дахь озоны зохистой хэмжээ ба түүний бөөгнөрлийн талаарх урт хугацааны зорилтуудыг тодорхойлсон. /Озон бол нарны гэрлийн тусгалын нөлөөгөөр нүүрс-устөрөгч ба азотын оксидуудын хооронд явагдсан химийн урвалын дүнд агаар мандалд бүрэлддэг хоёрдогч бохирдуулагч юм./ Түүнчлэн энэ баримт бичигт агаар дахь дэгдэмхий органик нэгдлүүд ба азотын оксидуудад хийгдэх мониторингийн тусгай шаардлагуудыг тодорхойлсон.
- 5. ЕП ба Консулын тогтоол 2004/107/ЕС.** Орчны агаар дахь хүнцэл, кадми, мөнгөн ус, никель болон олон циклт үнэрт нүүрс-устөрөгчдийн тухай энэхүү баримт бичиг нь "[Дөрөвдүгээр Дэд Тогтоол](#)" гэж нэршсэн бөгөөд Үндсэн Тогтоолд анх дурьдагдсан бохирдуулагч бодисуудын нэмэлт жагсаалтыг багтаасан. Мөнгөн усанд хийгдэх мониторингийн тусгай шаардлагуудыг тодорхойлсон.
- 6. Консулын тогтоол 85/203/ECC.** Азотын давхар ислийн хэмжээтэй холбогдсон агаарын чанарын стандартыг тодорхойлсон энэхүү баримт бичгийн заалтууд нь Нэгдүгээр Дэд Тогтоолын адил төстэй заалтууд Холбооны гишүүн орнуудад хуульчлан мөрдөгдөх хүртэл хүчин төгөлдөр хэвээр байна.
- 7. Консулын шийдвэр 97/101/ЕС.** Гишүүн орнуудын хүрээнд орчны агаарын бохирдлыг хэмждэг бие даасан станцууд болон сүлжээнээс тоо мэдээ, өгөгдөл харилцан солилцох журмыг тогтоосон. "[Еол Шийдвэр](#)" гэж нэрлэгддэг энэхүү баримт бичгийн дагуу агаарын чанарын мониторингийн талаарх мэдээллийг Гишүүн орнуудын зүгээс Комисст хүргүүлэх буюу олон нийтэд түгээнэ.
- 8. Комиссын тогтоол 2004/461/ЕС.** Консулын тогтоол 96/62/ЕС, 1999/30/ЕС болон Европын Парламент ба Консулын тогтоол 2000/69/ЕС, 2002/3/ЕС-ын дагуу Гишүүн орнуудын нутаг дэвсгэрт хийгдэх орчны агаарын чанарын үнэлгээний жил тутмын тайлангийн агуулга, загварыг баталсан.

➤ [Агаарын чанарын тухай шинэ тогтоол  
\(<http://ec.europa.eu/environment/air/directive.htm>\)](http://ec.europa.eu/environment/air/directive.htm)

Комисс агаарын бохирдолтой тэмцэх тусгай стратегийг баталсны зэрэгцээ орчны агаарын чанарын талаарх шинэ тогтоолын төслийг батлаад байна .

- Тогтоолын төсөл: [\*\*СОМ\(2005\) 447 final\*\*](#)
- Нөлөөллийн үнэлгээ: [\*\*SEC\(2005\) 1133\*\*](#)

Энэхүү шинэ тогтоолын төсөл нь дараах үндсэн элементүүдийг багтаасан.

Үүнд:

- Өнөөдрийн байдлаар хүчин төгөлдөр мөрдөгдөж буй олонх тогтоомж шийдвэрүүдийг (Дөрөвдүгээр Дэд Тогтоолоос бусдыг) агаарын чанарт тавигддаг өнөөгийн шаардлагуудыг өөрчлөхгүйгээр нэг ерөнхий тогтоол болгон нэгтгэх.
- PM2.5 буюу жижиг тоосонцортой (fine particles) холбогдуулан агаарын чанарын шинэ зорилго, мониторингийн шаардлага бий болгох.
- Агаар дахь бодисууд зөвшөөрөгдөх хэмжээний дотор байгаа эсэхийг хянахын зэрэгцээ байгалийн бохирдуулагч эх үүсвэрүүдийг багасгах боломжийг судлах.
- Бохирдуулагчдын зөвшөөрөгдөх дээд хэмжээг Холбооны нийт нутаг дэвсгэр дээр хуульчлан мөрдөж эхлэх хугацааг 5 хүртэл жилээр уртасгах.
- Тогтоолын төсөл нь хамтын шийдвэрийн журмаар батлагдах ба Сайд нарын Зөвлөл /Консул/ ба Европын Парламентын хоёулангаар нь сайшаагдан батлагдсаны дараа л хүчин төгөлдөр болно.
- ЕП тогтоолын төсөлтэй эхлэн танилцсаны дараа Консул мөн [\*\*бодлогын гэрээ\*\*-гээ баталсан болно.](#)
- Дараагийн шатанд Консулын нэгдсэн байр суурь тодорхойлогдож, Холбооны бүх албан ёсны хэл дээр бичигдэн Европын Парламентад хүргэгдсэний дараа тогтоолын төслийн хоёр дахь уншлага албан ёсоор эхлэн явагдана.

#### ➤ Агаарын чанарын стандартууд

Орчны агаарт бохирдуулагч бодис ихээр оршин байх нь хүний эрүүл мэндэд сөргөөр нөлөөлдөг. Тиймээс Европын Холбоо эрүүл ахуйн стандарт дээр үндэслэн агаар бохирдуулагч бодисуудын хүлцэх хэмжээг тодорхойлсон эрхзүйн цуврал баримт бичгүүдийг боловсруулан гаргасан. Тэдгээр стандарт шаардлагуудыг дараах хүснэгтэд нэгтгэн харуулав. Бохирдуулагч бодисуудын хүний эрүүл мэндэд нөлөөлөх үйлчлэлийн цаг хугацаа харилцан адилгүй байна.

- **Бохирдуулагчийн концентраци, Үйлчлэлийн хугацаа, Хүлцэх хязгаарыг хуульчлан мөрдөж эхлэх огноо, Жил тутамд зөвшөөрөгдөх дээд хэмжээ**

(Консул болон Европын Парламентаас агаарын чанарын тухай шинэ тогтоол батлагдвал энэхүү хүснэгтэн дэх мэдээлэлд өөрчлөлт орж болно.)

Агаарын чанарын талаарх Европын хууль тогтоомж тодорхой зарчмууд дээр суурилсан байдаг. Нэгдүгээрт, Гишүүн орнууд нутаг дэвсгэрээ бүс /zones/ болон суурин газрууд /agglomerations/ болгон хуваах ба тэдгээр бүс, суурин газрууд дахь агаарын бохирдлын түвшний үнэлгээг хэмжилт, загварчлал болон туршилтын бусад арга хэрэгсэл ашиглан хийнэ. Бохирдлын түвшин өндөр байвал Гишүүн орнууд бохирдуулагчийн хэмжээг хүлцэх хязгаарт байлгах

зорилт бүхий агаарын чанарын хөтөлбөр / төлөвлөгөө гарган хэрэгжүүлэх ба түүнчлэн, агаарын чанарын тухай мэдээллийг олон нийтэд түгээж байна.

## АГААРЫН ЧАНАРЫН ҮНДСЭН ТОГТООЛ

Сүүлийн жилүүдэд Европ агаарын чанарын асуудалд онцгой анхаарал хандуулах болсон. Европын Холбоо агаарын чанарын урт хугацааны зорилтууд төлөвлөх замаар энэ талын нэгдсэн стратеги бодлого боловсруулахыг зорьж ирсэн. Ингээд зарим тодорхой бохирдуулагч бодисын агаар дахь хэмжээ, концентрацид хяналт тавих үүднээс цуврал Тогтоолууд гаргаж хэрэгжүүлсэн. 1996 онд Байгаль орчны Консул орчны агаарын чанарын үнэлгээ, менежментийг багтаасан [Үндсэн Тогтоол 96/62/ЕС](#) батлав. Энэхүү Тогтоолоор өмнө нь мөрдөгдөж байсан хууль дүрмүүдийг шинэчилсэн бөгөөд өмнө нь ямар нэг эрхзүйн зохицуулалтгүй явж ирсэн бохирдуулагч бодисуудын хүлцэх хэмжээн дээр үндэслэсэн агаарын чанарын шинэ стандартыг нэвтрүүлсэн. Мөн бохирдуулагч бодисууд тус бүрт тавигдах шаардлагыг нарийвчлан тодорхойлох үүрэг бүхий дэд тогтоолуудыг боловсруулан гаргах цаг хугацааг тогтоож өгсөн. Агаар мандал дахь бохирдуулагч бодисуудын тоонд хүхрийн давхар исэл, азотын давхар исэл, тоосонцор /particulate matter/, тугалга, озон гэсэн өмнө нь хамрагдаж байсан бодисууд дээрээс нэмж бензол, нүүрстөрөгчийн дан исэл, полиаромат нүүрс-устэрөгч, кадми, хүнцэл, никель, мөнгөн усыг оруулсан.

## ДЭД ТОГТООЛУУД

- Үндсэн Тогтоолыг дагалдан гарсан дэд тогтоолууд нь дээр дурьдсан бохирдуулагч бодис тус бүр дээр тоогоор илэрхийлэгдэх хүлцэх хязгаарын хэмжээг тодорхойлж өгсөн. Түүнээс гадна мониторингийн стратеги, хэмжилтийн аргууд, тохируулга, чанарын үнэлгээний аргуудыг боловсронгуй болгох замаар EX-ны орнуудад нийтэд нь харьцуулан хэрэглэж болохуйц хэмжүүрүүдийг бий болгох, олон нийтийг оновчтой мэдээллээр хангах зорилго тавьсан.
- Дагалдах хууль тогтоомжуудыг боловсруулах ажлыг Комиссын мэргэжилтнүүд, аж үйлдвэр, байгаль орчны чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг ТББ-уудын төлөөллөөс бүрдсэн ажлын хэсгүүд гүйцэтгэдэг бөгөөд тэдний бэлтгэсэн баримт бичгийг Комисс хууль тогтоомжийн төслийн үндэс болгон ашигладаг. Мөн дээрх ажилд Европын Хүрээлэн буй Орчны Агентлаг (EXOA/EEA), Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллага (ДЭМБ/WHO), Нэгдсэн Үндэстний Байгууллагын Европын асуудал хариуцсан Эдийн засгийн Комисс (UN/ECE) болон ашигт зардлын шинжилгээний (CBA) болон бусад зөвлөх мэргэжилтнүүд тусlamж дэмжлэг үзүүлдэг. Эдгээр байгууллагууд, бүлгүүдийн төлөөллөөс бүрдсэн Удирдах Хороо ажлыг шууд удирдан зохион байгуулж явуулдаг юм.
- Үндсэн Тогтоол болон Дэд Тогтоолуудын аль аль нь Холбооны гишүүн орнууд дахь орчны агаарын чанарын үнэлгээг нэгдмэл арга, шалгуур дээр суурилан хийхийг шаарддаг. Иймээс Комисс [ЕК-ын агаарын чанарын тогтоолуудын хүрээнд урьдчилсан үнэлгээ хийх зааварчлага](#) ([pdf](#) ~1,100K); [EX-ны агаарын чанарын тогтоолуудын хүрээнд үнэлгээ хийх зааварчлага](#) ([pdf](#) ~520K) гэсэн баримт бичгүүдийг боловсруулан гаргасан.

## **Нэгдүгээр Дэд Тогтоол**

- [Нэгдүгээр Дэд Тогтоол \(1999/30/EC\)](#) нь орчны агаар дахь NOx, SO2, Pb ба PM10-ын хүлцэх хэмжээг тодорхойлдог бөгөөд 1999 оны 7-р сараас хүчин төгөлдөр үйлчилж эхэлсэн. Гишүүн орнууд уг тогтоолыг 2 жилийн дотор хүлээн авч хэрэгжүүлэх, мониторингийн стратегиа боловсруулах, мөн уг бодисуудын орчны тархалт, концентрацийн талаарх мэдээллийг олон нийтэд тогтмол мэдээлж байх үүрэгтэй. Үүний тулд тодорхой цаг хугацаа бүхий “хэрэгжүүлэлтийн төлөвлөгөө” гарган ажиллах ба түүнийгээ Комисс ба олон нийтийн сонорт хүргэнэ. Хөтөлбөр / төлөвлөгөө болон түүний хэрэгжилтийг мэдээлэх нарийвчилсан журмыг Комиссын Шийдвэр 2004/224/EC-ээр баталсан болно.

[Комиссын Шийдвэр 2001/744/EC](#)-ээр [Нэгдүгээр Дэд Тогтоол \(1999/30/EC\)](#)-д нэмэлт өөрчлөлт оруулсан.

- Тус Тогтоолын хүрээнд хийгдсэн Агаарын чанарын урьдчилсан үнэлгээний аргачлал, үр дүнг [Тайллан \(pdf ~410K\)](#)-д нэгтгэн оруулсан.
- Нэгдүгээр Дэд Тогтоолын хүрээнд хийгдсэн ажлын жил тутмын тайллан Комиссын Шийдвэр 2004/461/EC-ийн дагуу бэлтгэн хүргүүлнэ. Энэ журам Хоёрдугаар ба Гуравдугаар Дэд Тогтоолын жил тутмын ажлын тайланда нэгэн адил хамаарна.

**Холбогдох бусад материал:**

- [\(OJ L 156, 30 April 2004 p 78\)](#)
- Guidance to Member States on PM10 monitoring and intercomparisons with the reference method [\(pdf ~370Kb\)](#)
- [Guidance for the Demonstration of Equivalence of Ambient Air Monitoring Methods \(pdf ~540Kb\)](#), 2005 оны 5-р сар (9.5.2.2 дахь зүйл 2005 оны 11 сард шинэчлэн найруулагдсан).
- [Test the Equivalence](#)

## **Хоёрдугаар Дэд Тогтоол**

- [Хоёрдугаар Дэд Тогтоол \(2000/69/EC\)](#) нь орчны агаар дахь бензол, нүүрстөрөгчийн дан ислийн хүлцэх хэмжээг тодорхойлно. 2000 оны 12-р сарын 13-нд хүчин төгөлдөр болсон. Энэ Тогтоолын дагуу дээрх бодисуудын концентрацийн орчны агаарт агуулагдаж байгаа хэмжээг тэдгээрийн тогтоогдсон хязгаарыг үндэслэн нэгдсэн арга, шалгууруудаар шалгаж үнэлэх, мөн энэ талаарх мэдээллийг цуглувуулж олон нийтэд хүргэх үйл ажиллагаа хийгдэнэ.
- Нэгдүгээр Дэд Тогтоолын нэгэн адилаар Гишүүн орнууд “хэрэгжүүлэлтийн төлөвлөгөө” гарган ажиллах ба түүнийгээ Комисс ба олон нийтийн сонорт хүргэнэ. Хоёрдугаар Дэд Тогтоолын хүрээнд хийгдсэн ажлын [Жил тутмын тайланг](#) Комиссын Шийдвэр 2004/461/EC-ийн дагуу бэлтгэн хүргүүлнэ.

**Холбогдох бусад материал:**

- [Position paper on CO \(pdf ~360K\)](#)
- [Position paper on Benzene \(pdf ~360K\)](#)
- [EC Economic evaluation of Air Quality targets for CO and Benzene](#)

## Гуравдугаар Дэд Тогтоол

- Агаар мандал дахь озоны хэмжээ, найрлагыг тодорхойлоход чиглэсэн Гуравдугаар Дэд Тогтоол [2002/3/EC](#) 2002 оны 2 дугаар сарын 12-нд батлагдсан. 2003 оны 9 сарын 9 гэхэд Гишүүн орнууд хүлээж авах үүрэг хүлээсэн ба үүгээр түрүүчийн Тогтоол ([92/72/EC](#)) үйлчлэлээс гарна.
- Энэхүү Тогтоолоор ДЭМБ-с орчны агаар дахь озоны хэмжээг 2010 оны түвшнээр шинээр тогтоосонтой ижил хүрээний урт хугацааны зорилт тавьсан.
- Тэдгээр зорилтууд нь улс орны хэмжээнд хорт хийн ялгарлын цоорхойг багасгах Тогтоол (2001/81/EC)-ын дагуу тодорхойлогдсон. Гишүүн орнууд хөтөлбөр / төлөвлөгөө гарган ажиллах ба түүнийгээ Комисс ба олон нийтийн сонорт хүргэнэ. Озоны бөөгнөрлийг хянаж үнэлэн, ард иргэдэд бохирдлын бодит хэмжээг мэдээлэх талаар илүү нарийвчилсан боловсронгуй шаардлагуудыг энэ Тогтоолд тусгаж өгсөн.
- Мөн уг баримт бичигт озоны бөөгнөрлийн аюултай байж болох хэмжээг зааж өгсөн ба түүнээс илүү гарвал Гишүүн орнуудын холбогдох байгууллагууд яаралтай арга хэмжээ авах үүрэгтэй. Энэ тохиолдолд Комиссын Удирдамж Тайланд (\*) өгсөн жишээнүүдийг судлан хэрэгжүүлж болно.
- Гуравдугаар Дэд Тогтоолын хүрээнд хийгдсэн ажлын [Жил тутмын тайланг](#) Комиссын Шийдвэр 2004/461/EC-ийн дагуу бэлтгэн хүргүүлнэ.

*Холбогдох бусад материал:*

- [Ozone position paper \(pdf ~1.5M\)](#)
- [Guidance for Implementation \(pdf ~85K\)](#)

## Дөрөвдүгээр Дэд Тогтоол

- Европын Парламент ба Консултын [Тогтоол 2004/107/EC](#) 2004 оны 12 сарын 15-нд батлагдсан. Орчны агаар дахь хүнцэл, кадми, мөнгөн ус, никель болон олон циклт үнэрт нүүрс-устөрөгчдийн хүлцэх хэмжээг зааж өгсөн.

*Холбогдох бусад материал:*

- Position Paper on As, Cd and Ni
- [Position Paper \(pdf ~1900K\)](#)
- [Annexes \(pdf ~200K\)](#)
- Position Paper on PAH
  - [Position Paper \(pdf ~300K\)](#)
  - [Annexes \(pdf ~550K\)](#)
- Position paper on Mercury ([pdf format](#)) (шинэчлэгдсэн хувилбар, 2004 оны 2-р cap)
  - [Table of contents \(~60K\)](#)
  - [Executive Summary \(~80K\)](#)
  - [Recommendation and working group members \(~80K\)](#)
  - [Chapter 1 \(~170K\)](#)
  - [Chapter 2 \(~200/900K\)](#)

- [Chapter 3, figures 1, figures 2](#) (~200/2,000/3,200K)
- [Chapter 4](#) (~290K)
- [Chapter 5](#) (~210K)
- [Chapter 6](#) (~250K)
- [Chapter 7](#) (~130K)
- [EC Economic evaluation of Air Quality targets for PAH](#)
- [EC Economic evaluation of Air Quality targets for Heavy Metals \(pdf ~1.9M\)](#)

## **Европын Холбооноос 2002-2012 онд хүрээлэн буй орчны талаар баримтлах 6 дахь мөрийн хөтөлбөр**

"EX-ноос хүрээлэн буй орчны талаар баримтлаж байгаа бодлого нь иргэдийн амьдралд мэдэгдэхүйц үр нөлөө авчирч байгаа бөгөөд Европ дахинь аж үйлдвэрийг өндөр хөгжсөн хэд хэдэн салбарт дэлхийд тэргүүлэгч болоход тусалсан. Гэвч энэхүү ахиц дэвшлийн хажуугаар биологийн төрөл зүйлийг хамгаалах явдал одоо болтол бүрэн хяналтад ороогүй, хүрээлэн буй орчны бохирдол хүн амын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлсөөр, хог хаягдлын хэмжээ ихэссээр байна. Тиймээс Комисс дээрх асуудлуудыг шийдвэрлэхэд түлхэц болгохын тулд Хүрээлэн буй орчны мөрийн хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлэхэд бүх хүч чармайлтаа дайчлах болно".

(Байгаль орчны Комиссар Ставрос Димас, 6 дахь Мөрийн хөтөлбөрийн хэрэгжилтийн явцын дүнгийн хурал, 2007).

Хүрээлэн буй орчны 6 дахь мөрийн хөтөлбөр нь хүрээлэн буй орчны асуудлуудыг өргөн хүрээнд авч үзэж 2012 он хүртэл хугацаанд Комиссоос хүрээлэн буй орчны талаар баримтлах бодлогын чиглэлийг тодорхойлдог.

### **Хүрээлэн буй орчны 6 дахь мөрийн хөтөлбөр гэж юу вэ?**

- [Хүрээлэн буй орчны 6 дахь мөрийн хөтөлбөр](#) гэдэг нь Европын Парламент ба Консулаас 2002 оны 7 сарын 22-ны өдөр батлан гаргасан баримт бичиг юм. Энэхүү хөтөлбөр нь Европын холбооноос 2002-2012 онд хүрээлэн буй орчны талаар баримтлан явуулах бодлогын чиглэлийг тодорхойлж, хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх зорилтуудыг биелүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааг төлөвлөж өгсөн
- Хүрээлэн буй орчны 6 дахь мөрийн хөтөлбөрт дараахь 4 асуудлыг нэн тэргүүний зорилт болгон авч үзсэн. Үүнд:
- [Үүр амьсгалын өөрчлөлт](#)
- [Унаган байгаль, биологийн төрөл зүйл](#)
- [Хүрээлэн буй орчин, эрүүл мэнд](#)
- [Байгалийн баялгууд ба хог хаядал](#).
- Хүрээлэн буй орчны 6 дахь мөрийн хөтөлбөрт хүрээлэн буй орчныг хамгаалах шаардлагуудыг Холбооны бүх бодлого шийдвэр, үйл ажиллагаанд тусгах зорилт дэвшүүлсэн ба уг хөтөлбөр нь өөрөө тогтвортой хөгжилд чиглэсэн Холбооны стратегийн хүрээлэн буй орчны хэсгийг бүрдүүлж өгч байна. Хөгжил дэвшил, өрсөлдөөн, ажил эрхлэлтийн талаар Европын тавьж буй зорилтууд ба хүрээлэн буй орчны бодлогын хооронд тодорхой уялдаа холбоо бий болсон.

### **Ямар арга хэрэгсэл байх вэ?**

- Хүрээлэн буй орчны 6 дахь мөрийн хөтөлбөрийн хүрээнд хөрс ба усны орчин (биологийн төрөл зүйлийн гол чухал асуудлуудаас), агаар, пестицид, хотын орчин (байгаль орчин, эрүүл мэнд, амьдралын чанарын гол чухал асуудлуудаас), байгалийн нөөц баялаг, хог хаягдлын дахин боловсруулалт (байгалийн баялаг ба хог хаягдалтай холбоотой гол чухал асуудлуудаас) гэсэн чиглэлүүдээр [долоон тусгай Стратеги](#) боловсруулж хэрэгжүүлэх юм.
- Тэдгээр тусгай стратеги нь ЕХ-ны түвшинд дээр дурьдсан гол зорилт бүрээр хийгдэх үйл ажиллагааны ерөнхий чиглэлийг тодорхойлно.
  
- [Агаарын бохирдолтой тэмцэх стратеги](#), [Орчны агаарын чанар ба Европын цэнгэг агаарын тухай тогтоол](#) болон тэдгээрийн [Нэлөөллийн үнэлгээ](#) нь "Европын цэвэр агаар" (CAFE) хөтөлбөрийн хүрээнд Комиссоос боловсруулан гаргасан холбогдох бусад баримт бичгүүд дээр суурилсан болно. (<http://ec.europa.eu/environment/air/cafe/general/keydocs.htm>). Тэдгээрийг дурьдвал:
- [Стратеги, чиглэл](#)
- [Арга зүй](#)
- [Үнэлгээний загварчлал ба ашигт зардлын шинжилгээний хослол](#)
  - [Суурь тайлан](#)
  - [Ажлын тайлан](#)
  - [Зураглал](#)
  - [Тоо баримтын хүснэгтүүд](#)
- [Арга хэмжээ](#)
- [Сонирхлын булгууд ба олон нийтийн зөвлөлдөөн](#)

<http://ec.europa.eu/environment/air/cafe/general/keydocs.htm#maps>

### Агаарын бохирдолд нэлөөлж буй хүчин зүйлсийн зураглал

- [Жижиг тоосонцорын нэлөөллийн улмаас дундаж наслалт багасах нь](#)
- [Газрын түвшин дэх озон эрүүл мэндэд нэлөөлөх нь](#)
- [Ойн экосистем дэх хүчлийн хуралдал](#)
- [Хээрийн экосистем дэх хүчлийн хуралдал](#)
- [Цэнгэг усны савууд дахь хүчлийн хуралдал](#)
- [Азотын хэт их хуралдал](#)
- [Озон буудайн ургацанд нэлөөлөх нь](#)

### Тоо баримт харуулсан хүснэгтүүд

- Хорт хийн ялгарал, түүнийг бууруулах үйл ажиллагааны өртөг зардал. Агаарын чанарыг дээшлүүлэх нь
- Эрүүл мэндийн хүчин зүйлс
- [Эрүүл мэндэд учирч буй нэлөөллийг Европын нийт тохиолдол ба гишүүн орон тус бүрээр тооцоолсон нь](#)
- [Тоосонцор болон тоосонцор ба озона хүний эрүүл мэндэд учруулж буй нэлөөллийн эдийн засгийн судалгаа, Европын нийт тохиолдол ба гишүүн орон тус бүрээр](#)
- [Цэвэр ашиг, зардал ба ашгийн харьцаа, гишүүн орон тус бүрээр.](#)

/Слайд/

### **Жижиг тоосонцорын нөлөөллийн улмаас дундаж наслалт багасах нь**

Хүний үйл ажиллагааны улмаас үүссэн PM2.5 тоосонцорын нөлөөгөөр дундаж наслалт багасах тооцоо, 2000 оны байдлаар. (Цаг агаарын байдлын тооцоо 1997 оныхоор).

/Слайд/

### **Агаар мандал дахь тоосонцор /жижиг биетүүд/ хүний эрүүл мэндэд нөлөөлөх нь**

**Хүснэгт 25. PM<sub>10</sub>-ын концентраци 50-100 µg/m<sup>3</sup> байх үед хүний эрүүл мэндэд 3-аас дээш хоногийн хугацаагаар сөрөг өөрчлөлт орох байдал (сая хүн тутамд)**

Эрүүл мэндийн сөрөг өөрчлөлт	PM <sub>10</sub> -ын нөлөөлөлд 3-аас дээш хоног өртсөн хүний тоо	
	50 µg/m <sup>3</sup>	100 µg/m <sup>3</sup>
Нас баралт	4	8
Амьсгалын замын эрхтэний өвчлөлийн улмаас хэвтэж эмчлүүлсэн	3	6
Цацлага хэрэглэсэн /хүн-өдөр/	4863	10514
Өвчин хүндэрсэн /хүн-өдөр/	5185	11267

**Хүснэгт 25. 10-20 µg/m<sup>3</sup> концентрацитай PM<sub>2.5</sub>-ын нөлөөлөлд удаан хугацаагаар өртсөний улмаас хүүхдийн эрүүл мэндэд сөрөг өөрчлөлт орох байдал (жилээр, сая хүн тутамд 200 000 хүүхдээр)**

Эрүүл мэндийн сөрөг өөрчлөлт	PM <sub>2.5</sub> -ын нөлөөлөлд нэг жилийн дотор өртсөн хүүхдийн тоо	
	10 µg/m <sup>3</sup>	20 µg/m <sup>3</sup>
Мөгөөрсөн хоолойн өвчлөлийн шинж тэмдэг шинээр илэрсэн	3350	6700
Ушигны үйл ажиллагаа (FVC, FEV) нь байвал зохих хэмжээнээс 85% буюу түүнээс бага	4000	8000